



# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 01 сарын 20 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

## ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл нэмсүгэй:

**1/15.35 дугаар зүйл:**

**“15.35 дугаар зүйл. Дотоодын цэргийн хамгаалалтад байгаа объектод тогтоосон журам зөрчих**

1. Дотоодын цэргийн хамгаалалтад байгаа объектод:

1.1. объектод зориулалтын бус газраар нэвтрэхийг оролдсон, нэвтэрсэн;

1.2. объектод зөрчилтэй нэвтрэх бичиг баримтаар нэвтрэхийг оролдсон;

1.3. объектын хамгаалалтад үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчаас бусад этгээд зэвсэгтэй нэвтрэхийг завдсан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Дотоодын цэргийн хамгаалалтад байгаа объектын нутаг дэвсгэрт:

2.1. нэвтрэх эрх бүхий хүнд саад хийсэн;

2.2. агаарын зайд нисгэгчгүй, зайнаас удирддаг агаарын хөлгөөр нислэг үйлдсэн бол зөрчлийг арилгуулж, хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

**2 дугаар зүйл.** Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн “Тайлбар” хэсгийн “цагдаа,” гэсний дараа “дотоодын цэрэг,” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР